



САНГИЙН САЙД Ч.УЛААН  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013. 05. 06 № 06/108 ЧАТ-САТ/2013/08-СМА-М8

Г Зөрчил арилгах тухай Г

Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 213 дугаар тогтоол, Сангийн сайдын мөн өдрийн 297 дугаар тушаалаар Засгийн газрын үнэт цаасыг олон улсад сурталчлах, худалдан борлуулхтай холбогдон гарсан зардал 5,376,858.0 ам.доллартай тэнцэх эх үүсвэрийг Засгийн газрын үнэт цаасны хүүгийн зардлаас нөхөн санхүүжүүлэхээр шийдвэрлэж, нотлох баримтгүйгээр 7,483.5 сая төгрөгийг хүүгийн зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

“Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12 дугаар заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1 дүгээр заалтыг үндэслэн дээрх алдаа, зөрчлийг зогсоож, анхан шатны баримтыг бүрдүүлэх, давтан гаргахгүй ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт, Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга Т.Доржханд нарт үүрэг болгож, албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг 2013 оны 6 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ АУДИТОР

Ч.БОЛД



070283